

ЖИЛИЙН ТАЙЛАН

2023

АГУУЛГА

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ	03
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	04
БИЗНЕСИЙН ТАЙЛАН	05
САНХҮҮГИЙН ҮР ДҮН	09
ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	15
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	18
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	20
НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	23
ТЭНГЭРИЙН ЗАСАГЛАЛ	31
АУДИТЫН ТАЙЛАН	40

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Ш.ГАНТУЯА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Нийт харилцагч, даатгуулагчид, хувьцаа эзэмшигчдээ!

Нийт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийнхээ нэрийн өмнөөс та бүхэндээ мэндчилгээ дэвшүүлж байна.

Тэнгэр даатгалын цэвэр ашиг 2023 онд өмнөх оноос 71 хувиар өсөж 5.1 тэрбум төгрөгийн ашигтайгаар маш амжилттай ажиллаа.

Мөн салбартаа нөхөн төлбөр олголтоор тэргүүлж нийт нөхөн төлбөрийн хүсэлтийн 97 хувьд нөхөн төлбөр олголоо.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос даатгалын компаниудад тавьдаг хамгийн гол үзүүлэлт болох төлбөрийн чадварын харьцаагаар бүх даатгалын компаниудаас нэгдүгээрт 176 хувийн харьцаатайгаар орлоо. Энэ нь Тэнгэр Даатгал эрсдэл даах өндөр чадамжтайг харуулж байна.

2023 онд санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын ОУ-ын Стандарт ("СТОУС") 17 буюу Даатгалын гэрээний шинэ стандартад нийцүүлж тайлагнаснаар Монгол Улсын даатгалын салбарт анхдагч компани боллоо.

Тэнгэр Даатгал 2013 оноос хойш тасралтгүй Олон Улсын аудитын компаниар санхүүгийн тайландаа аудит хийлгэж байгаа цорын ганц Монголын даатгалын компани юм. 2023 оны аудитаа мөн олон улсын Нексиа аудитын компаниар хийлгэлээ. Мөн Тэнгэр Даатгал нь банк, санхүүгийн байгууллагаас авсан ямарваа нэг өр зээлгүй болно.

Бид салбартаа ашигт ажиллагаа, нөхөн төлбөрийн үйлчилгээгээрээ тэргүүлэн санхүү бүртгэлээрээ үлгэр жишээ болж ажиллаж байгаагаас гадна нийгмийн хариуцлагын ажил хийдэг.

Монголчуудынхаа эрүүл мэндийн мэдлэгт хувь нэмэр оруулах зорилгоор edoctor.mn веб сайт ажиллуулж байна. Тус сайт сард 500 мянгаас 1 сая хандалт аван эрүүл мэндийн үнэ төлбөргүй мэдээлэл түгээснээр Монголдоо №1 хандалттай эрүүл мэндийн платформ боллоо.

2023 онд Мандал Санхүүгийн Нэгдэлтэй хамтран Үндэсний Эрсдэлийн Форум зохион байгуулж улс даяараа эрсдэлийн асуудлаар бүтэн 3 хоног хэлэлцүүлэг өрнүүллээ.

Эцэст нь хэлэхэд Тэнгэр даатгалын ТУЗ нь МУ-ын хууль дүрэм, засаглалын кодексыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж ирсэн бөгөөд цаашид корпорацийн зөв засаглалын үлгэр жишээ байр сууриа хадгалж ажиллахаа үүгээр мэдэгдэхэд таатай байна.

ХҮНДЭТГЭСЭН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Шаравпэлжээгийн ГАНТУЯА

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Ж.БААТАРБОЛД

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүдээ,

Тэргүүн ээлжид надад итгэл хүлээлгэсэн бүх хүнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. 23 жилийн түүхтэй Тэнгэр даатгал компанийг удирдах ховор боломж олгосныг миний бие хувьцаа эзэмшигчид, харилцагчид, ажилтнууд болон бүхий л оролцогч талуудын өмнө хүлээх асар өндөр үүрэг хариуцлага хэмээн ухамсарлаж байна.

Компанийн хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж өнөөдрийн Тэнгэр даатгалыг бүтээсэн үе үеийн ТУЗ-н дарга, гишүүд,

гүйцэтгэх удирдлагууд, ажилтнууд та бүхнээр бахархаж, талархаж байна.

Тэнгэр даатгал нь 2022 оны эцсээр Мандал санхүүгийн нэгдлийн 100%-ийн хөрөнгө оруулалттай болсноор компанийнхаа онцлог, өвөрмөц давуу талуудаа хадгалахын зэрэгцээ шинэ стратеги, менежментийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж 2023 онд түүхэн амжилт, үр дүн гарган ажиллалаа.

Олон нийтийн эрсдэл ба даатгалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд шинэлэг контентууд бэлтгэн нийтэлснээр олон зуун мянган хүнд хүрч, компанийн сошиал хуудсыг дагагчдын тоо 70,000-д давж 2 дахин нэмэгдлээ.

2023 оны байдлаар 75 ажилтан, 5 салбар, 63 төлөөлөгч, 10 зуучлагч, 5 банкны өргөн сүлжээ болон өөрийн цахим сувгуудаар дамжуулан даатгалын үйлчилгээ үзүүлснээр 33,440 иргэн, 1,778 байгууллагуудтай нийт 56,681 даатгалын гэрээ байгуулж, 8.7 их наяд төгрөгийн болзошгүй эрсдэлийг даатгасан.

Санхүүгийн үзүүлэлтүүдээс онцолбол Цэвэр хураамжийн орлого 13.2 тэрбум(+63.4% YoY), Нийт хөрөнгийн хэмжээ 36.3 тэрбум (+10.8% YoY) төгрөг, Даатгалын нөөц сан 9.9 тэрбум (+18% YoY) төгрөг, Нийт мөнгө хөрөнгө 30.3 тэрбум (+24.6% YoY) төгрөг, Хөрөнгө оруулалтын орлого 3.7 тэрбум (+86.0% YoY*) төгрөг, цэвэр ашиг 5.1 тэрбум (+71.4% YoY*) төгрөг хүрлээ.

Корпорэйт харилцагчдын хөрөнгөд үнэ төлбөргүй эрсдэлийн үнэлгээ хийж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр манай мэргэшсэн баг ажиллаж байна.

SCOR re, Hannover re, Mongolian re компаниудтай 5 сая долларын хамгаалалттай давхар даатгалын трити гэрээтэй ба үүнээс өндөр үнэлгээтэй даатгалыг BHSI, Chubb, if, AIG, Allianz зэрэг олон улсад нэр хүнд бүхий давхар даатгалын компанид давхар даатгалаа.

Даатгалын зах зээлд мэргэжлийн стандарт тогтоох алсын хараатай, Даатгалаар хамгаалагдсан ирээдүйг иргэн бүрд хэмээх эрхэм зорилгыг өмнөө тавьсан Тэнгэр даатгалын хамт олон бид хүлээсэн үүргээ биелүүлж, 2024 онд стратегийн зорилтуудаа хэрэгжүүлж ажиллахын төлөө бүхий л оюун ухаан, хүч чадлаа дайчлан ажиллах болно.


*YoY Өмнөх оны мөн үеэс өөрчлөлт

ХҮНДЭТГЭСЭН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Жуковын БААТАРБОЛД


БИЗНЕСИЙН ТАЙЛАН

САЛБАРЫН ТОЙМ



ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТИЙН ТҮВШИН

2023 оны хувьд манай улсын даатгалын гүнзгийрлийн түвшинд огцом өөрчлөлт гараагүй бөгөөд 0.1 функтээр өсч 0.58 хувьд хүрсэн байна. Үүнд даатгалын хураамжийн орлого болон ДНБ-н өсөлтийн хэмжээ ойролцоо түвшинд байсан нь нөлөөлжээ.



*Даатгалын гүнзгийрэлт гэж даатгалын нийт хураамжийн орлогыг ДНБ-д харьцуулсан харьцаа.

2023 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 18 даатгалын компанийн 238 салбар, 12 төлөөлөгчийн газар болон нийт 63 даатгалын зуучлагч компанийн 405 салбараар дамжуулан 713 даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг нийт **1.3 сая даатгуулагч хувь хүн болон 266 мянган даатгуулагч хуулийн этгээдэд хүргэжээ.**

Мөн 18 даатгалын компанийн 1103 ажилтан даатгалын чиглэлээр мэргэшин иргэд, даатгуулагчдад мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ хүргэн ажиллаж байна.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО

Ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлого 2023 оны эцсийн байдлаар 388.0 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 90.8 тэрбум төгрөгөөр буюу 30%-аар өссөн байна.

Бүтээгдэхүүний хэлбэрээр нь харвал өмнөх оны мөн үеэс авто тээврийн хэрэгслийн даатгал 38.3 тэрбум төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 16.6 тэрбум төгрөгөөр, жолоочийн хариуцлагын даатгал 8.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Нийт хураамжийн орлого нь сүүлийн 4 жилийн турш, **жилд дунджаар 20%-ийн өсөлттэй гарчээ.**

Хураамжын орлого, тэрбум.төг



НӨХӨН ТӨЛБӨР

2023 оны хувьд манай улсын даатгалын гүнзгийрлийн түвшинд огцом өөрчлөлт гараагүй бөгөөд 0.1 функцээр өсөж 0.58 хувьд хүрсэн байна. Үүнд даатгалын хураамжийн орлого болон ДНБ-ний өсөлтийн хэмжээ ойролцоо түвшинд байсан нь нөлөөлжээ.

2023 онд Монгол Улсын 16 буюу түүнээс дээш насны иргэдийг нийт даатгуулагч хувь хүний тоотой харьцуулахад 54.4 хувьтай байгаа нь даатгалын гэрээ байгуулах насны 2 хүн тутмын 1 нь даатгалтай гэж харагдаж байна. Уг үр дүнд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөлөөлөл их юм.

МӨНГӨН ХӨРӨНГӨ


Ердийн даатгалын компаниудын мөнгөн хөрөнгө 2023 оны жилийн эцсийн байдлаар 284.5 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс **53.6 тэрбум төгрөгөөр буюу 23%-аар өссөн** байна. Мөнгөн хөрөнгө нь сүүлийн 4 жилийн турш, жилд дунджаар 15%-ийн өсөлттэйгөөр нэмэгджээ.

Ердийн даатгалын компаниудын хөрөнгө оруулалтыг авч үзвэл үнэт цаас хэлбэрээр оруулж буй хөрөнгө оруулалтын өсөлтийн хувь хамгийн өндөр байгаа бол нөгөөтээгүүр хадгаламж, хадгаламжийн сертификатад оруулах хөрөнгө оруулалтын өсөлт буурч байгаа юм.

Үүнд Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн холбогдох дүрэм, журмуудад Хорооны 2023 оны 559 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж, даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, даатгалын нөөц сан, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахтай холбоотой зохицуулалтыг сайжруулж, даатгагчдын хувьцаа болон бондод оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хөшүүрэг болсон нь нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

МӨНГӨН ХӨРӨНГӨ:

/тэрбум.төг/



БИЗНЕСИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ҮР ДҮН




АШИГТ АЖИЛЛАГАА


Тэнгэр Даатгал нь 2020 оноос хойш үр ашигтай бүтээгдэхүүн болон сегмент рүү үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан. Хэдий компанийн баримталж буй бодлогын үр дүнд хураамжийн орлого буурсан ч, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд гол хүчин болсон.

2023 онд Тэнгэр Даатгалын цэвэр ашиг 5.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос **71.4%-р өссөн**. Цаашлаад, компанийн **өөрийн хөрөнгийн өгөөж 29.7% болсон**.

Цэвэр ашиг
тэрбум.төг



Өөрийн Хөрөнгийн Өгөөж - ROE
тэрбум.төг



НИЙТ ХӨРӨНГӨ

2023 онд компанийн нийт хөрөнгө 36.3 тэрбум төгрөг болж 10.8% буюу **3.5 тэрбум төгрөгөөр өссөн** байна.

Нийт Хөрөнгө
тэрбум.төг




ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГО


Тэнгэр Даатгалын цэвэр хураамжийн орлого 2023 онд 13.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Бид 2020 оноос эхлэн үр ашигтай бүтээгдэхүүн болон сегмент рүү үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласны үр дүнд компанийн хураамжийн орлого 2020, 2021 болон 2022 онуудад буурсан хэдий ч 2023 оноос эхлэн үр ашигтай сегментээ улам тэлж цэвэр хураамжийн орлогоо нэмэгдүүлж чадсан.

Компанийн баримталж ирсэн бодлогын үр дүнд цэвэр хураамжийн орлого **өмнөх оноос 63.4%-р өссөн.**

ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГО:
/тэрбум.төг/



ЦЭВЭР ХУРААМЖИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ:
/бүтээгдэхүүнээр/




● Авто тээврийн хэрэгслийн даатгал	59%
● Хөрөнгийн даатгал	13%
● Жолоочийн хариуцлагын даатгал	13%
● Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	11%
● Хариуцлагын даатгал	4%
● Бусад	0%

НӨХӨН ТӨЛБӨР

Тэнгэр Даатгал нь 2023 онд нийт нөхөн төлбөр нэхэмжилсэн 2,544 харилцагчийн 2,479 харилцагчдад 4.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон буюу нийт нөхөн төлбөрийн хүсэлтийн 97.4%-г нь олгосон байна.

Компани нь харилцагчдынхаа бүх төрлийн эрсдэлийг тооцож даатгалын нөөц санг байгуулдаг. Нөхөн төлбөр олгоогүй 2.6% нь даатгалын гэрээ нь дууссан, эсвэл даатгалын гэрээгээ хамгаалагдаагүй эрсдэл тохиолдсон, эсвэл нөхөн төлбөрийн луйвар хийх оролдлого зэрэг шалтгаантай байсан.

Нийт Нөхөн Төлбөр
тэрбум.төг



Өөрийн Хөрөнгийн Өгөөж - ROE
тэрбум.төг



Компани нь 2020 оноос хойш баримталсан бодлогын үр дүнд даатгалын нөөц сангаа сүүлийн 4 жилд тогтвортой түвшинд барьж чадсан байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Тэнгэр Даатгал нь 2023 онд 5.9 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргасан бөгөөд өмнөх оноос 15.7%-р өссөн байна. Зардлын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь, үнийн өсөлт, борлуулалтын зардал болон хүний нөөцтэй холбоотой зардлууд юм. Үйл ажиллагааны зардлын өсөлт нь цэвэр хураамжийн орлогын өсөлтөөс бага байгаа нь компанийн орлогоо нэмэгдүүлэх бодлого нь үр дүнтэй, үр ашигтай байгааг илтгэж байна.

Үйл Ажиллагааны зардал
тэрбум.төг




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Тэнгэр Даатгалын 2023 оны цэвэр ашгийн 72%-г хөрөнгө оруулалтын орлого бүрдүүлж байна.

Компани нь 2023 онд хөрөнгө оруулалтын стратегийг нарийн гаргаж өндөр өгөөжтэй ажилласны үр дүнд **хөрөнгө оруулалтын орлого 3.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 86%-н өсөлтийг үзүүлсэн.**

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО:
/тэрбум.төг/



НИЙЛМЭЛ ХАРЬЦАА

Нийлмэл харьцаа гэдэг нь зардлын харьцаа болон хохирлын харьцааны нийлбэр юм. Энэ үзүүлэлт нь бага байх тусам компанийн ашигт ажиллагаа сайн байгааг харуулдаг.

2023 онд даатгалын салбарын дундаж 110%-тай байсан ба даатгалын үйл ажиллагаанаасаа алдагдалтай ажилласан байна. Харин Тэнгэр Даатгалын хувьд нийлмэл харьцаа нь 86%-тай гарсан ба даатгалын үйл ажиллагаанаасаа 14%-ийн ашигтай ажилласан болно.

НИЙЛМЭЛ ХАРЬЦАА:
/тэрбум.төг/




ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА

Санхүүгийн Зохицуулах Хорооноос төлбөрийн чадварын харьцааг 110%-с өндөр байх ёстой гэж заасан байдаг.

2023 онд **Тэнгэр Даатгалын төлбөрийн чадварын харьцаа 176%** гарсан нь даатгалын салбартаа хамгийн өндөр төлбөрийн чадвартай компани гэдэг байр сууриа хадгалсан үзүүлэлт болсон. Төлбөрийн чадварын харьцаа нь өндөр байх тусмаа компанийн харилцагч болон оролцогч талуудын эрхийг хангах болон ямарваа нэгэн төлбөр тооцоо хоцрох болон төлбөр хийх чадамжгүй болох эрсдэлээс сэргийлж байгааг илтгэдэг.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА:
/тэрбум.төг/





БИЗНЕСИЙН ТАЙЛАН

ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Тэнгэр Даатгал” ХХК нь трийти гэрээгээр хамгаалагдахгүй болон трийти гэрээний хязгаараас давсан хэсгийн эрсдэл, Эрсдэлийн удирдлагын бодлогод нийцэхгүй эрсдэлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон давхар даатгагчид тавих олон улсын зэрэглэлийн шалгуур үзүүлэлтийг баримтлан Олон Улсад нэр хүнд бүхий санхүүгийн зэрэглэл өндөртэй давхар даатгагчдад багцлан эсхүл эрсдэл тус бүрээр үнэлэн давхар даатгуулан ажиллаж байна.

ТРИЙТИ ДАВХАР ДААТГАЛ

Даатгалын компани өөрийн сонгосон эрсдэлүүдээ оновчтой удирдах нэг арга бол давхар даатгалд байршуулах бөгөөд тухайн хамгаалалтын бүхий л нөхцөлийг давхар даатгагчидтай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр трийти буюу гэрээт (багц) давхар даатгалын хамгаалалтыг худалдан авдаг.

Тэнгэр даатгалын хувьд 2 төрлийн трийти хамгаалалттай. Компанийн хариуцлагаас давсан хэсгийг трийти давхар даатгалаар Франц Улсын давхар даатгагч Скор РЭ, Герман Улсын давхар даатгагч Ханновэр РЭ, Монгол Улсын давхар даатгагч “Үндэсний Давхар Даатгал” ХК-тай гэрээлэн, хөрөнгө, хөрөнгийг дагасан бизнес тасалдал, барилга, угсралтын бүх эрсдэл, байгууллагын ерөнхий хариуцлага, бүтээгдэхүүний хариуцлага, мэргэжлийн хариуцлага, ажил олгогчийн хариуцлага, хүнд даац, тусгай зориулалтын машин механизм, ачаа тээврийн гээд нийт 8 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг давхар даатгуулан ажиллаж байна.


КОМПАНИЙН ТРИЙТИ ДАВХАР ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ХАМГААЛАЛТ:

Бүтээгдэхүүний төрөл	Даатгалын хамгаалалт /ам.доллар/
Хүнд даац, тусгай зориулалтын машин механизмын даатгал	2,000,000
Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал	3,000,000
Бүтээгдэхүүний хариуцлагын даатгал	3,000,000
Мэргэжлийн хариуцлагын даатгал	3,000,000
Ажил олгогчийн хариуцлагын даатгал	3,000,000
Ачаа тээврийн даатгал	3,000,000
Хөрөнгийн даатгал	5,000,000
Барилга угсралтын бүх эрсдэлийн даатгал	5,000,000

Хувь тэнцүүлсэн трийти давхар даатгалаар Лойдед бүртгэлтэй Сириус 1945 даатгалын компанитай гэрээлэн, гадаад аяллын даатгалын бүтээгдэхүүнийг 50.0 мянган ам.доллар хүртэлх хамгаалалттайгаар давхар даатгуулан ажиллаж байна.

Даатгалын тохиолдол гарсан үед гэрээгээр даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн, нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэх нь маш чухал. Иймд, бид олон улсын санхүүгийн үнэлгээний агентлагуудаас А болон түүнээс дээш үнэлгээ авсан давхар даатгагчидтай трийти давхар даатгалын гэрээний хүрээнд хамтарч ажиллаж байна.

Хамтран ажилладаг давхар даатгалын компани, брокер:

Давхар даатгагчид	Олон улсын үнэлгээ
	A+ (AM BEST)
	A+ (AM BEST)
	BB+ (AM BEST)
	A+ (S&P)

Гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгал буюу Гадаад аяллын даатгал

Бид Шенгений бүс нутагт хамаарах европ тивийн 26 орон болон АНУ-ын виз хүсэгчдэд тавих шаардлагыг хангахуйц өндөр хамгаалалттай гадаадад зорчих үедээ гэнэтийн осол болон өвдөх зэргээс үүдэн гарах төлөвлөөгүй зардлаас хамгаалах олон улсын жишиг болохуйц гадаад аяллын даатгал санал болгодог.

Бидний санал болгож буй даатгал нь давхар даатгалын хамгаалалттайгаас гадна ковидын хамгаалалт нэмэлтээр авч болдгоороо давуу талтай.

Berkshire Hathaway Specialty Insurance (BHSI) давхар даатгалын компанийн Монгол Улс дах албан ёсны хамтрагч даатгалын компани

Олон улсын даатгалын зах зээлд A++ (A.M.Best) болон AA+ (Standard & Poors) үнэлгээтэй дэлхийн томоохон давхар даатгалын компаниудын нэг болох Berkshire Hathaway Specialty Insurance (BHSI) давхар даатгалын компани болон “Тэнгэр Даатгал” ХХК нь хамтын ажиллагааны гэрээг 2021 онд байгуулсан.

“Тэнгэр Даатгал” ХХК-ийн нээлттэй засаглал, төлбөрийн чадварын сайн үзүүлэлт, олон улсын BIG 4 аудитын компаниар баталгаажсан санхүүгийн тайлагнал, зохицуулагч байгууллагаас өгсөн байнгын өндөр үнэлгээ зэрэгт үндэслэн BHSI компанийн зүгээс хамтран ажиллах саналыг ирүүлж Монгол Улс дахь албан ёсны хамтрагч байгууллагаар сонгогдон хамтын ажиллагаа улам бүр өргөжүүлсээр байна.

БИЗНЕСИЙН ТАЙЛАН
**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэр Даатгал нь хөрөнгө оруулалтаа Даатгалын тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд, мөн Санхүүгийн Зохицуулах Хорооны даатгалын багц дүрмийн хүрээнд удирддаг болно.

Компани нь ердийн даатгалын компани болохынхоо хувьд хөрөнгө оруулалт хийхэд эрсдэлийг хамгийн өндөр түвшинд удирдах шаардлагатай байдаг ба нөхөн төлбөртэй уялдуулан хөрвөх чадварыг ханган ажилладаг.

2023 онд компанийн нийт мөнгөн хөрөнгө 30.3 тэрбум төгрөг болсон ба энэ нь өмнөх оноос 24.6%-ийн өсөлт юм.

2023 оноос эхлэн Тэнгэр Даатгал нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг улам нарийн болон өндөр өгөөжтэй байхаар боловсруулж ажилласан. Үүний үр дүнд компани нь 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлоготой ажиллаж, хөрөнгө оруулалтын өгөөж 15.9%-д хүрсэн байна, харин даатгалын салбарын дундаж өгөөж 9.7%-тай байна.


Нийт мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын дүн нь компанийн нийт хөрөнгийн 83%-ийг бүрдүүлдэг.

Бид нийт мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын дүнг оновчтой удирдаж хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа амжилттай болсны үр дүнд компанийн цэвэр ашгийн 72%-г бүрдүүлж байна.

НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ

2023 онд компанийн нийт мөнгөн хөрөнгө 30.3 тэрбум төгрөг болж 24.6% буюу **6 тэрбум төгрөгөөр өссөн** байна.

Нийт Мөнгөн Хөрөнгө
тэрбум.төг



БИЗНЕСИЙН ТАЙЛАН

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэл хүлээн авах нь даатгалын бизнесийн үйл ажиллагааны томоохон үүрэг хэдий ч үнэн хэрэгтээ, даатгалын компаниуд эрсдэлийг хүлээн авахдаа урьдчилан тодорхойлсон эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээнд байгаа эсэхийг хянаж, холбогдох бодлогын дагуу шийдвэр гарган ажилладаг.

Тэнгэр Даатгал ХХК-ийн эрсдэлийн удирдлагын нэгж нь энэхүү зарчмыг бодит байдалд хэвшүүлэхийн төлөө ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаа, стратеги төлөвлөлтдөө хэвшүүлснээр тогтвортой өрсөлдөх чадварыг бий болгох юм.

Бид харилцагчаа хамгаалах бодлогыг нэн тэргүүнд баримтлан ажилладаг. Үүний хүрээнд харилцагчдын үйл ажиллагааны онцлог, шаардлага, хэрэгцээнд тулгуурласан даатгалын бүтээгдэхүүн, хамгаалалтыг санал болгохоос гадна тэдгээрийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг удирдах зөвлөмжүүдийг хүргүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

Мөн харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг ямагт биелүүлэхийн тулд хүрэлцээтэй буюу зохистой хэмжээний нөөц сан байгуулах нь Тэнгэр даатгал ХХК-ийн хувьд өндөр ач холбогдолтой бөгөөд эрх бүхий байгууллагуудын зүгээс хүрэлцээтэй гэсэн үнэлгээг тогтмол авсаар ирлээ.

Зохицуулагч байгууллага болох Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос хэрэгжүүлж буй Эрсдэл ба төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт (Own Risk and Solvency Assessment, ORSA)-ийг зах зээлийн тэргүүлэгчдийн нэгийн хувиар тус компани амжилттай хэрэгжүүлж байна.

“Эрсдэлийн удирдлагын тогтолцоо” нь байгууллагын эрсдэлийн удирдлагын гол бичиг баримт ба үүгээр байгууллагын хэмжээнд ашиглагдах эрсдэлийн удирдлагын стандарт, хэмжээг зааж өгсөн. Энэхүү бичиг баримт нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо хэрхэн ажиллах, тодорхойлсон эрсдэлийн дагуу эрсдэлийг үнэлэх мөн байгууллагын хүрээнд эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоож өгсөн байдаг.

Эрсдэлийн аппетит нь голлох харьцаануудыг олон сценарид зорилтот түвшнээс хазайх хазайлтын хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг заана. Эрсдэлийн аппетит нь голлох харьцаануудыг олон сценарид зорилтот түвшнээс хазайх хазайлтын хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг заана.

Тэнгэр Даатгалын эрсдэлийн удирдлагын функцийн зорилго нь эрсдэлийн удирдлагыг бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаа, стратеги төлөвлөлтөд суулгаж тогтвортой өрсөлдөх давуу байдлыг бий болгоход оршино.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Бид эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа дараах гурван шатны хамгаалалтыг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг. Ингэхдээ тухайн эрсдэл бүрээс шалтгаалж дараах зохих шатны хамгаалалтуудыг хийдэг. Тухайн хамгаалалт бүрд хариуцсан газар нэгжийн түвшинд үйл ажиллагаа хийгддэг байна.

Эрсдэлийн төрөл	Нэгдүгээр шатны хамгаалалт	Хоёрдугаар шатны хамгаалалт	Гуравдугаар шатны хамгаалалт
Даатгалын эрсдэл	Эрсдэл хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх Удирдлагын Хороо	ТУЗ
Санхүүгийн эрсдэл (Авлагын эрсдэл)	Санхүү хариуцсан захирал	Гүйцэтгэх Удирдлагын Хороо	ТУЗ
Санхүүгийн эрсдэл (Зах зээлийн эрсдэл)	Санхүү хариуцсан захирал	Гүйцэтгэх Удирдлагын Хороо	ТУЗ
Санхүүгийн эрсдэл (Хөрвөх чадварын эрсдэл)	Санхүү хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх Удирдлагын Хороо	ТУЗ
Үйл ажиллагааны эрсдэл	Газар, нэгж бүр	Гүйцэтгэх Удирдлагын Хороо	Дотоод аудит

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

“ЭРСДЭЛ БА СТАНДАРТ” ФОРУМЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Манай улсад төдийгүй дэлхий дахинаа тулгамдаж буй нэн тэргүүний асуудлын нэг гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд стандарт мөрдүүлэх явдал нэн чухал байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы ивээл дор “Эрсдэл ба Стандарт” үндэсний чуулганыг орон даяар гурван өдөр зохион байгуулагдсан.

Төрийн ордонд болсон “Эрсдэл ба стандарт” үндэсний форумд холбогдох яам, агентлаг, 21 аймгийн төр захиргааны болон олон улсын байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, “Мандал Санхүүгийн Нэгдэл” тэргүүтэй хувийн хэвшил, бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжүүд, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, иргэний нийгмийн байгууллагын 2400 гаруй оролцогч оролцсон.



ТЭНГЭР ДААТГАЛ БОЛОН ХАСБАНК ХАМТРАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ДААТГАЛЫГ НЭВТРҮҮЛЭВ

НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сангийн магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болох ХасБанк эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизмыг Тэнгэр Даатгалтай хамтран **Монголд анх удаа нэвтрүүлж, олон нийтэд танилцуулах арга хэмжээг 2023 онд амжилттай зохион байгуулсан.**



ТАНЫ БИЗНЕСТ ЯАГААД
**ЭРЧИМ ХҮЧНИЙ
ХЭМНЭЛТИЙН
ДААТГАЛ**
ХЭРЭГТЭЙ ВЭ?




**ТАНИЛЦУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭ**
02 - 06 - 2023 • ДАВАА ГАРАГ
BLUE SKY DIAMOND HALL



Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын тогтолцоо, түүнд оролцогч талуудад бий болох давуу тал болон даатгалын механизмын цахим платформын талаар танилцуулсан уг арга хэмжээнд төслийн зөвлөх, НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн Хамтын ажиллагааны төв болох BASE ТББ болон төслийг хэрэгжүүлэгч ХасБанк, Тэнгэр Даатгал, Юрика байгууллагуудын төлөөллүүд илтгэл тавьж, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж, технологи нийлүүлэгч болон худалдан авагч, Санхүүгийн зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо зэрэг холбогдох талуудад нэгдсэн ойлголт, мэдээлэл өгөн ажилласан.

Эрчим хүчний хэмнэлтийн даатгалын механизм нь зөвхөн даатгалын бүтээгдэхүүн бус санхүүгийн болон бусад механизмыг хослуулан сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гол хөшүүрэг юм.

The background of the page is a dramatic photograph showing the silhouettes of firefighters in full protective gear. They are positioned in front of a massive fire that fills the upper half of the frame with a bright, intense orange and yellow glow. The firefighters' equipment, including helmets and breathing apparatus, is clearly visible against the light. The overall mood is heroic and emphasizes the danger and scale of the firefighting work.

АМЬ ЭРСЭДСЭН ГУРВАН АЛБАН ХААГЧИЙН АР ГЭРТ МӨНГӨН ТУСЛАМЖ ОЛГОВ

Өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн, албан үүргээ гүйцэтгэж яваад харамсалтайгаар алтан амиа алдсан Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 63 дугаар ангийн **3 албан хаагчийн ар гэрт Тэнгэр даатгалаас нийт 150 сая төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж олгов.**

Эдгээр эрсдэлийн баатрууд нь өөр даатгалын компанид даатгалтай байж магадгүй. Үүнийг үл харгалзан “Тэнгэр Даатгал” ХХК-ийн хамт олны зүгээс Монгол улсын эрсдэлийг бууруулахын төлөө мөр зэрэгцэн зүтгэдэг зорилго нэгт гурван анд нөхдийнхөө гэгээн дурсгалд зориулан энэхүү мөнгөн тусламжийг олгов.

EDOCTOR

Монголын хамгийн анхны эрүүл мэндийн цогц платформ юм.

Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал асуудал байдаг.

Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид бүх насныханд зориулсан эрүүл мэндийн боловсрол олгох цогц платформыг нэвтрүүлсэн билээ.

1 САЯ

тогтмол уншигч


250+

өвчний дэлгэрэнгүй мэдээлэл

100+

зөвлөмж нийтлэл


Бид өдгөө 1 сая гаруй тогтмол уншигчтай болсон бөгөөд мэргэжлийн эмч нарын бэлтгэсэн 250 гаруй өвчний дэлгэрэнгүй мэдээлэл, 100 гаруй зөвлөмж нийтлэл, шинж тэмдэг дээр суурилсан өвчний асуумж ба зөвлөмж, эрүүл мэндийн тооцоолуур, эмнэлэг хайх зэрэг олон зүйлийг нэг дор багтаасан өргөн мэдээллийн сантай болоод буй.



edoctor.mn

ASUUNA

Өсвөр нас бол эрсдэлтэй зан үйлд татагдах хамгийн өндөр эрсдэлтэй үе байдаг тул энэ хугацаанд хүүхдийг үнэн зөв, баталгаатай, мэргэжлийн мэдээллээр хангах нь чухал юм.



Уг хэрэгцээ шаардлагад үндэслэн бид 2022 оноос эхэлж ASUUNA платформыг хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Энэхүү платформ нь 13-18 насны хүүхдүүдэд эрүүл мэнд, үерхэл нөхөрлөл, сэтгэл зүй, өсвөр насны хөгжлийн онцлогтой холбоотой үүсдэг олон асуултуудад мэргэжилтнүүдийн бэлтгэсэн хариултыг хүргэдэг.



БАЙГАЛЬ ОРЧИН

100%-ИЙН УРГАЛТТАЙ “ТЭНГЭР ТӨГӨЛ”-Д 800 МОД АМЖИЛТТАЙ ТАРЬЖ, УРГУУЛАВ

“Тэнгэр Даатгал” ХХК нь 2021 онд 20 жилийн ойгоо тохиолдуулан тогтвортой хөгжлийн зорилгоо биелүүлэх, компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 3 га газар төгөл үүсгэн байгуулж услалтын системийг шийдэж, мод тарих, арчлан ургуулах төслийг өөрийн хөрөнгөөрөө хэрэгжүүлж эхэлсэн билээ.

“Тэнгэр төгөл”-д 6 нэр төрлийн 500 ширхэг модны суулгац тарьсан ба тогтмол усалгаа, арчилгаа хийсний үр дүнд 100% ургахын зэрэгцээ адил хугацаанд тарьсан модноос өндөр ургалттай байгааг дуулгахад таатай байна. 2022 оны хаврын тарилтад ХасБанк хамтран оролцож Өрөл, Голтбор (150ш), Далан хайс (150ш), Шар хуайс (160ш), Хайлаас (110ш), Улиас (50ш), Бургас (30ш) зэрэг 7 нэр төрлийн 800 мод нэмж тарьсан бол 2023 онд **250 мод нэмж тарьснаар нийтдээ 11 төрлийн 1,550 модтой боллоо.**

Мод дагаж ус, ус дагаж амьдрал гэдэг.

“Тэнгэр даатгал” ХХК-ийн хамт олон ирээдүй хойч үедээ амьсгалах цэвэр агаар, ногоон байгууламжийг үлдээх зорилго өвөрлөн “Тэнгэр Төгөл”-ийг жилээс жилд өргөжүүлж, модны ургалтад анхаарал хандуулан ажилласаар байх болно.



ЗҮРХ МАРТАХГҮЙ

Төрөлхийн зүрхний гажиг нь дэлхийд 100 төрөлт тутамд 1 тохиолддог. Монгол улсад жилдээ дунджаар 1,000 зүрхний төрөлхийн гажигтай хүүхэд төрдөг ба 20-30% нь зайлшгүй хагалгаанд орох шаардлагатай байдаг. Харин **“Зүрх Мартахгүй”** төсөл нь хүүхдийн зүрхний төрөлхийн гажгийг үнэ төлбөргүй эмчлэх санаачилга гарган ажиллаж, 2020 онд нийт 80 гаруй хүүхдэд амжилттай хагалгаа хийсэн байна.

Тэнгэр Даатгал компани нийгмийн хариуцлагын хүрээнд энэхүү ажлыг дэмжиж **“Зүрх Мартахгүй” төслийн хамт олонд 20 сая төгрөг хандивлалаа.**

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТЭНГЭР ДААТГАЛ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“Тэнгэр Даатгал” ХХК нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Засаглалын кодексыг бүх ажилтан, албан тушаалтнууд сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг “Тэнгэр Даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) хянадаг.

Тайлант хугацаанд “Тэнгэр Даатгал” ХХК-ийн засаглалын гол оролцогч талууд болох Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага ба түүний багийн гишүүд нь даатгалын салбарын цаг үеийн шинжтэй аливаа нөхцөл байдлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн өөрчлөлтөд дасан зохицож, тулгарсан асуудлуудыг шийдвэрлэж онцлох амжилтаар дүүрэн жил байв.

“Тэнгэр Даатгал” ХХК-ийн ТУЗ нь засаглалын практикийг олон улсын жишиг болон ёс зүйн хэм хэмжээний хүрээнд хууль тогтоомжийн дагуу, тогтвортой, тууштай баримтлахыг үүрэг болгон ил тод, хариуцлагатай байдлыг эрхэмлэж, салбарын стандартад үлгэр жишээ соёлыг төлөвшүүлэхийг зорьдог.

Тайлант хугацаанд даатгалын стратегийн шийдвэрүүдийг эрсдэлийн удирдлагын зохистой зарчимд тулгуурлан компанийн тогтвортой байдал, бизнесийн үйл ажиллагааны тэлэлт, ил тод байдлыг чухалчилж ажиллалаа. Хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын итгэлцэлд ТУЗ-ийн амлалт нэн чухал тул засаглалын тогтолцооныхоо үр нөлөөг нэмэгдүүлэхийн төлөө хичээн ажилладаг.

Манлайлал

Компанийн засаглалын тогтолцоог бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилладаг соёлыг төлөвшүүлэх чиг хандлагыг тодорхойлоход ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын багтай нягт хамтран ажилладаг бөгөөд шударга ёс, шинийг санаачлагч, стратегийн алсын харааг зарчим болгосон шийдвэрийг ямагт хэрэгжүүлж байдаг.

ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын баг нь цаг үетэй уялдуулан холбогдох дүрэм журмыг шинэчлэн үйл ажиллагаагаа явуулдаг билээ. “Тэнгэр Даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, амжилт, тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг мэргэжлийн туршлагатай оролцогч талуудыг төлөөлсөн хараат бус гишүүдээс бүрдсэн байна.

Стратеги ба гүйцэтгэл

“Тэнгэр Даатгал” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид солигдсонтой холбоотой шинэ бодлого стратегийг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна. Стратеги шинэчлэлийн хүрээнд “Тэнгэр Даатгал” ХХК-ийн томоохон бодлого, журмуудыг шинэчлэн сайжруулсан.

Тухайлбал:

- Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
- Аудит Эрсдэлийн хорооны журам;
- ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, залгамж халааны журам;
- Эрсдэлийн удирдлагын бодлого;
- Андеррайтингийн заавар;

Стратеги төлөвлөлт хийх процессыг сайжруулаад зогсохгүй бид төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлийн хяналт, гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг тогтмол сайжруулахад анхаарч ажилладаг. Төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээллүүдийг тогтмол ТУЗ-д тайлагнахаас гадна Дотоод аудитын газраар тогтмол давхар баталгаажуулалт хийгдэж байна.

Мөн Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, гэрээний үзүүлэлтүүдийг хувь хүн болон баг хамт олон, компанийн нийт гүйцэтгэлтэй уялдуулж, бие даан шийдвэр гаргах, нэг зорилгын дор багийн нийцэл ажиллагааг тэнцвэртэй үнэлэн дүгнэдэг.

ТЭНГЭР ДААТГАЛ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Ёс зүй

Байгууллагын соёл, дотоод эерэг уур амьсгалыг бэхжүүлэх болон нийт ажилтны дагаж мөрдөн үйл ажиллагаандаа баримтлах чухал засаглал болон соёлын бодлогын баримт бичиг болох “Ёс зүйн дүрэм”-ийг ТУЗ-өөс санаачлан баталсан. Шинэ санаачилгыг дэмжиж 2023 оны 06 дугаар сарын 28-ны тогтоолын хавсралтаар баталсан нь компанийн ёс зүйн хэм хэмжээг дэмжих томоохон амжилт болсныг онцлох нь зүйтэй.

Тэнгэр Даатгал ХХК-ийн засаглалын тогтолцоо

“Тэнгэр Даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний дийлэнх хувийг хараат бус гишүүд эзэлж байна. Энэ нь ТУЗ-ийн тогтолцоо нэг талын нөлөөнд автсан шийдвэр гаргах эрсдэлгүй, хамгийн эрүүл гэдгийг батлан харуулж байна. ТУЗ-ийн удирдан чиглүүлэх үндсэн ажлыг гүйцэтгэхэд өндөр хувь нэмэр оруулахуйц санхүүгийн мэргэшсэн мэргэжилтнүүдээр зөвлөлөө бүрэлдүүлсэн. 2023 онд “Тэнгэр Даатгал” ХХК-ийн ТУЗ нийт 19 удаа ээлжит болон ээлжит бус байдлаар хуралдаж, 42 асуудлыг шийдвэрлэн Тогтоол гаргасан байна.

Компанийн засаглалын бүтэц



Тэнгэр Даатгалын засаглалын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах:

www.tengerdaatgal.mn/about



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ш.ГАНТУЯА | ТУЗ-ийн дарга
21+ жилийн туршлага

Ш.Гантуяа нь “Юу Эм Си Капитал” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрээр 1998-2002 онд Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд сургуулийн Бизнесийн удирдлагын Бакалавр мэргэжлээр төгссөн.

Ш.Гантуяа нь өмнө нь “Монгол Ньюс” ХХК-д Маркетингийн хэлтсийн захирал, “Улаанбаатар зочид буудал” ХХК-д Маркетингийн албаны даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай.



Т.БАТЗУЛ | ТУЗ-ийн хараат бус гишүүн
15+ жилийн туршлага

Т.Батзул нь Мандал Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрээр 2009 онд Их Британийн Уэлсийн их сургуулийн бизнесийн удирдлагаар магистр зэрэг хамгаалсан.

Т.Батзул нь 2009 онд Тэнгэр Даатгал ХХК-ийн газрын захирал, 2011 онд Мандал Даатгал ХХК-ийн Газрын захирал, 2015-2019 онд Голомт Банкны Газрын захирлаар ажиллаж байсан, Монголын банк санхүү, даатгалын салбарт 12 гаруй жил ажилласан туршлагатай.



Р.АМАРЖАРГАЛ | ТУЗ-ийн хараат бус гишүүн
42+ жилийн туршлага

Р.Амаржаргал нь 1982 онд Москва хотын Плехановын нэрэмжит Улс Ардын Аж Ахуйн Дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр, 1995 онд Брэд Фордын их сургуулийг Макро эдийн засгийн бодлого, төлөвлөлтөөр судалгаа хийж шинжлэх ухааны магистр зэрэг хамгаалсан. 2019 онд докторын зэрэг хамгаалсан.

Тэрээр 1982-1983 онд Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв зөвлөлд зааварлагч, 1983-1990 онд Цэргийн нэгдсэн дээд сургуульд, 1990-1991 онд Техникийн Их Сургуульд багш, 1991-1996 онд Эдийн засгийн коллежийн захирлаар ажиллаж байсан.

Түүнчлэн 1996-2000, 2004 оноос эхлэн УИХ-ын гишүүнээр дараалан 3 дах удаагаа сонгогдож байсан. 1998-1999 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад хэргийн сайд 1999-2000 онд Монгол Улсын Ерөнхий сайд ажиллаж байсан бөгөөд, 1996 оноос одоо хүртэл СЭЗИС-н Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Доктор, Профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд цолтой.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ц.ТҮМЭНЦОГТ | ТУЗ-ийн хараат бус гишүүн 17+ жилийн туршлага

Ц.Түмэнцогт нь Монголын бизнесийн зөвлөлийн Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна. Тэрээр 1993 онд ОХУ-ын Москва хотын Эрчим Хүчний Дээд сургуулийг эрчим хүчний магистр, 2001 онд АНУ-ын Индианагийн Их сургуульд төрийн удирдлагаар магистр зэрэг хамгаалсан.

Ц.Түмэнцогт нь 2007-2011 онд Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар дэд бүтцийн мэргэжилтэн, төслийн удирдагч, 2011-2016 онд Женерал электрик компанийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн газарт гүйцэтгэх захирал, 2016-2018 онд Эрдэнэс Монгол ХХК-д гүйцэтгэх захирал, 2018-2019 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамд сайдын зөвлөх, 2018-2021 онд

Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Эрдэнэс Оюу Толгой (ЭОТ) ХХК-д Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай.



Г.ТУУЛ | ТУЗ-ийн хараат бус гишүүн 26+ жилийн туршлага

Г.Туул нь 2012 оноос хойш ХасБанк ХК-ийн Эко Банкны Газрын захирлаар ажиллаж байна. Тэрээр Компьютерын Техник Менежментийн сургуулийг Компьютерын техникч, программист мэргэжлээр, Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр тус тус төгсөж, Колорадогийн Техникийн Их Сургуульд Санхүүгийн чиглэлээр Бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан.

Г.Туул нь 1998-2001 онд Хадгаламж банкны Нэгдсэн бодлогын газарт Эдийн засагч, Дилер, 2001-2008 онд ХасБанканд Банкны үйлчилгээний хэлтсийн захирал, Улаанбаатар хотын Бүсийн захирал, 2010-2012 онд Монгол улсын

анхны хувийн тэтгэврийн сан болох МТНД ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан, Монголын банк санхүүгийн салбарт 20 гаруй жил ажилласан туршлагатай.



Б.ЭНХТҮВШИН | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 21+ жилийн туршлага

Б.Энхтүвшин нь “Тэнгэр Даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна. Тэрээр 2002 онд Худалдаа Үйлдвэрлэлийн дээд сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр, 2009 онд Монгол улсын их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан.

Б.Энхтүвшин нь 2003-2011 онд Тээвэр Хөгжлийн Банканд Зээлийн эдийн засагч, Гадаад төлбөр тооцооны албаны дарга, Дотоод төлбөр тооцооны албаны дарга, Хөрөнгө удирдлагын газрын захирал, 2011-2013 онд “Мандал Даатгал” ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал, 2015-2016 онд ТаванБогд

Интернэйшнл ХХЗ Санхүү албаны дарга, 2018-2019 онд Нано Интернэйшнл ХХК Санхүү албаны дарга, 2019 оноос одоог хүртэл “Мандал Даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, 2023 оноос одоог хүртэл “Тэнгэр Даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Аудит эрсдэлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн нь 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолоор өөрчлөн батлагдсантай холбоотойгоор Аудит эрсдэлийн хороо нь дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Үүнд:

Дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн	Р.Амаржаргал
---------------------------	--------------

Гишүүд:

ТУЗ-ийн дарга	Ш.Гантуяа
ТУЗ-ийн гишүүн	Т.Батзул

Аудит эрсдэлийн хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, компанийн нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байна. Дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын тайлан, илэрсэн зөрчил, зөвлөмжүүд нь Аудитын хороонд шууд тайлагнагддаг.

Мөн тус хороо нь компанийн нийт эрсдэл буюу санхүүгийн ба санхүүгийн бус эрсдэл, даатгал, үйл ажиллагааны болон комплаенсийн эрсдэлийг удирдах асуудлыг компанийн бодлогын хэмжээнд хангаж ажиллах, хэрэгжилтийг хянах гол чиг үүрэгтэй. Тиймээс тус хорооны журамд тусгагдаж, бүтцээр хангагдсанаар Эрсдэл хариуцсан захирал, Комплаенс хариуцсан ажилтан нь тус хороонд тайлагнах журамтай бөгөөд Эрсдэл хариуцсан захирлын гол анхаарч ажиллах асуудал болон жилийн төлөвлөгөөтэй танилцаж, үүрэг зөвлөмжөөр ханган ажилладаг.

Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Үүнд:

Дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн	Ц.Түмэнцогт
---------------------------	-------------

Гишүүд:

ТУЗ-ийн дарга	Ш.Гантуяа
ТУЗ-ийн гишүүн	Т.Батзул

Тус хороо нь Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгч ажилладаг болно. Хороо нь ТУЗ-ийн гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлагатай холбоотой шалгаруулалт, цалин, урамшууллыг зөв зохистой тодорхойлж, тэдний ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнэх, ТУЗ-д санал болгох, зөвлөх зорилго, үүрэгтэй хороо юм.

Мөн Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой дүрэм, журамтай танилцаж, хянан хэлэлцэж зөвлөмжөө өгч ажилладаг. Тиймээс компанийн борлуулалт болон төвийн нэгжийн цалингийн систем, тэдгээрийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем, сонгон шалгаруулах журам, ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох журам, ажилтнуудын халамж тэтгэмжийн журам гэх зэрэг холбоотой бичиг баримтуудтай танилцаж, санал өгдөг. Мөн хүний нөөцтэй холбоотой дараах явцын тайлангуудтай танилцдаг болно.

Үүнд:

- Дараа жилийн Хүний нөөцийн төлөвлөгөө, цалин урамшууллын зардлыг энэхүү хороогоор урьдчилан хэлэлцэж, саналаа өгсний дараа компанийн төсөв, төлөвлөгөөнд тусгагддаг болно.
- Хүний нөөцийн хэлтсийн захирлаас хүний нөөцтэй холбоотой гол анхаарал асуудлууд, хийх ажлын төлөвлөгөөтэй танилцдаг.
- Хүний нөөцийн хөдөлгөөн, шилжилт хөдөлгөөний анализ хийж, ирээдүйн төлөвлөгөө, соёлын арга хэмжээнүүдийг авч ажилладаг.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Ж.БААТАРБОЛД | Гүйцэтгэх Захирал 20+ жилийн туршлага

Гүйцэтгэх захирал Жуковын Баатарболд нь банк санхүү, даатгалын салбарт 20 дахь жилдээ ажиллаж байгаа чадварлаг удирдагч юм.

Тэрээр ажлын гараагаа 2004 онд ХасБанкнаас эхлүүлж, тус банканд салбарын удирдлага, иргэдийн банкны чиглэлээр 16 жил ажиллаж, иргэдийн банкны чиглэлээр олон өөрчлөлт, шинэчлэлтийн төслүүдийг амжилттай удирдсан туршлагатай.

Улмаар 2020 оны 1-р сард Тэнгэр даатгалын Иргэдийн даатгал хариуцсан захирлаар томилогдон ажиллах хугацаандаа компанийн өрсөлдөх чадварыг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан.

Жуковын Баатарболд нь Санхүү эдийн засгийн дээд сургуулийг банкны удирдлага мэргэжлээр бизнесийн удирдлагын бакалавр, Люксембургийн Их Гүнт улсын Люксембургийн их сургуулийг банк санхүүгийн мэргэжлээр магистрын зэрэгтэй төгссөн.



Г.ХАЛИУНАА | Үйл ажиллагаа хариуцсан захирал 14+ жилийн туршлага

Г.Халиунаа нь 2023 оны 1 сараас эхлэн Тэнгэр даатгал компанийн үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байна.

Тэрээр банк, санхүүгийн байгууллагад 7 жил ажилласан туршлагатай. Дурдвал 2019-2023 оны хооронд Мандал Даатгал ХК-д Санхүү хариуцсан захирлаар, 2018-2019 оны хооронд Голомт банканд Удирдлагын мэдээллийн хэлтсийн захирлаар тус тус ажилласан туршлагатай.

Г.Халиунаа нь МУИС-ийн Санхүү эдийн засгийн сургуулийг санхүү менежментийн чиглэлээр бакалавр зэрэгтэй төгссөн.



О.БАТЖАРГАЛ | Эрсдэл хариуцсан захирал 16+ жилийн туршлага

О.Батжаргал нь Монгол Улсын Их Сургуулийг хэрэглээний математикч мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд Тэнгэр даатгал компанид буюу даатгалын салбарт 16 дахь жилдээ тууштай, хариуцлагатайгаар ажиллаж байна.

Тэрээр Монгол улсын анхны актуарчдын нэг бөгөөд актуар, давхар даатгал, нөхөн төлбөр, андеррайтинг, эрсдэлийн удирдлага гэсэн даатгалын салбарын маш чухал чиглэлээр туршлага хуримтлуулсан байна.

О.Батжаргал нь ажиллах хугацаандаа Япон улсын Даатгалын холбооны ээлжит сургалтад амжилттай хамрагдаж, даатгалын салбарын актуар, андеррайтинг, эрсдэлийн удирдлагын чиглэлээр ахисан түвшний, даатгалын хохирол үнэлэгчийн тусгай эрхтэй, мэргэшсэн ажилтан юм.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

М.ЭНХЦЭЦЭГ | Санхүү бүртгэлийн хэлтсийн захирал 10+ жилийн туршлага

М.Энхцэцэг нь “Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль”-ийг Санхүү менежмент чиглэлээр бакалаврын зэрэг, АНУ-н “California University of Management & Science” сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэргээр тус тус төгссөн бөгөөд банк санхүүгийн салбарт 8 жил ажилласан туршлагатай.

Тэрээр 2015-2023 оны дуустал Голомт банканд Санхүүгийн менежер, Ахлах санхүүгийн менежерээр ажилласан бөгөөд 2024 оны 1 сараас эхлэн Тэнгэр даатгал компанийн Санхүү, бүртгэлийг хариуцан ажиллаж байна.



Г.ХОНГОРЗУЛ | Байгууллагын даатгалын газрын захирал 13+ жилийн туршлага

Г.Хонгорзул нь 2023 оны 6 сараас эхлэн Тэнгэр даатгал компанийн Байгууллагын даатгалын газрын захирлаар ажиллаж байна.

Тэрээр даатгалын салбар 2007 оноос хойш ажилласан туршлагатай. Дурдвал 2007- 2011 оны хооронд Номин Даатгал ХХК-д Даатгалын мэргэжилтнээс ахлах менежер, 2011-2014 оны хооронд Тэнгэр Даатгал ХХК-д Байгууллагын даатгалын ахлах менежер, 2016-2023 оны 6 сар хүртэл Мандал Даатгал ХК-ийн Корпорэйт даатгалын Ахлах менежерээр тус тус ажилласан туршлагатай.

Г.Хонгорзул нь Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн харьяа Билиг ХЗДС-ийг Эрх зүйч /даатгал/, ХУИС-ийн Англи хэл орчуулагчийн анги тус тус чиглэлээр бакалавр зэрэгтэй төгссөн. Мөн БНХАУ, Бээжин, Swiss Re түргэвчилсэн сургалтад хамрагдсан байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Д.БИЛГҮҮН | Байгууллагын даатгалын газрын захирал 9+ жилийн туршлага

Д.Билгүүн нь 2023 оны 11 сараас эхлэн Тэнгэр даатгал компанийн Байгууллагын Даатгалын Газрын захирлаар ажиллаж байна.

Тэрээр БНСУ-д Олон Улсын Үзэсгэлэн Яармаг менежментийн чиглэлээр ажлын гараагаа эхэлсэн ба 2015-2017 онуудад Алтан Дорнод Монгол ХХК-д Дотоод Хяналтын захирлаар ажилласан туршлагатай.

2018-2020 онуудад аялал жуулчлалын салбарт М-Трип платформын төслийг удирдаж ажилласан туршлагатай ба 2022 онд монголын анхны айл гэр, албан байгууллагын бүх төрлийн үйлчилгээнүүдийг нэг дор багтаасан Мон Сервис хэмээх гар утасны аппликэйшнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.

Д.Билгүүн нь БНХАУ-ын Олон Улсын Эдийн Засаг болон Худалдааны Их Сургуулийг Олон Улсын Худалдаа ба Эдийн Засагч бакалавр болон БНХАУ-ын Шанхайн Их Сургуулийг Хэрэглээний Эдийн Засагч Магистр зэрэгтэй төгссөн.

Мөн БНХАУ-ын Олон Улсын Эдийн Засаг болон Худалдааны Их Сургуулийн Цахим Худалдаа ба Логистик болон Испани улсын Барселонагийн Их Сургуульд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Хуулийн мэргэжил дээшлүүлэх сургалтуудад тус тус хамрагдсан байна.



Х.НУРГҮЛ | Иргэдийн даатгалын газрын захирал 13+ жилийн туршлага

Х.Нургүл нь Сэрүүлэг дээд сургуулийг Бизнесийн менежмент, Нягтлан бодогч мэргэжлээр амжилттай суралцаж төгссөн бөгөөд, ХасБанк ХХК-д 2011-2022 онд теллер, нягтлан бодогч, харилцагчийн үйлчилгээний мэргэжилтэн, зээлийн мэргэжилтэн, 2022 оноос “Тэнгэр даатгал” ХХК-д зуучлал хамтын ажиллагааны менежерээр ажиллаж байх хугацаандаа Банкны даатгалын зуучлал, хамтын ажиллагаа, харилцаа холбоог шинэ шатанд гарган, сайжруулах тал дээр шинэлэг байдлаар ажиллаж, харилцагчийн үйлчилгээгээр манлайлан өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байсан туршлагатай.

Х.Нургүл нь 2023 оны 11 сараас эхлэн Тэнгэр даатгал компанийн иргэдийн даатгалын газрын захирлаар ажиллаж байна.



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН



НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Юу Би Тавэр Плас барилга, 609 тоот
Баянгзүрх дүүрэг, 25 дугаар хороо
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 7740 4848
Веб хаяг: www.nexia.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид “Компани” гэх)—ийн 2023 оны 12 дугаар сарын 31—ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31—ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)—ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)—уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”—ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС—ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”—ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид



Э.Булган


Э.БУЛГАН
Партнер

У.Нарандэлгэр

У.НАРАНДЭЛГЭР
Аудитор

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2024 оны 2 дугаар сарын 26

НЕКСИА ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Нексия Интернэйшнл-ийн албан ёсны, биеэ даасан гишүүн
Веб: www.nexia.com



“ТЭНГЭР ДААТГАЛ” ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг,
алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

(Дахин тайлагнасан*)

Мянган төгрөгөөр	2023	2022
Даатгалын орлого	10,516,230	8,740,068
Даатгалын үйлчилгээний зардал	(4,534,762)	(3,767,501)
Даатгалын үйлчилгээний үр дүн	5,981,468	4,972,567
Давхар даатгалын хураамжийн төлөлт	(39,353)	(404,590)
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	171,351	703,833
Давхар даатгалын цэвэр үр дүн	131,998	299,243
ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭВЭР ҮР ДҮН	6,113,466	5,271,810
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	3,248,822	1,998,237
Бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө оруулалтын цэвэр олз	349,090	-
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз	133,168	-
Санхүүгийн хөрөнгө, гэрээний хөрөнгийн үнэ цэний бууралтын өөрчлөлтөөс үүссэн олз, гарз (үнэ цэний бууралтын буцаалтыг оруулсан)	(5,193)	(19,522)
Цэвэр хөрөнгө оруулалтын орлого	3,725,887	1,978,715
Бусад олз / (гарз)	333,121	(30,033)
Бусад үйл ажиллагааны зардал	(4,412,732)	(3,890,436)
Бусад санхүүгийн зардал	(16,599)	(5,202)
Татварын өмнөх ашиг	5,743,143	3,324,854
Орлогын албан татварын зардал	(585,670)	(315,701)
Тайлант жилийн цэвэр ашиг	5,157,473	3,009,153
Бусад дэлгэрэнгүй орлого	1,165,223	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	6,322,696	3,009,153

*Аудитлагдсан санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17 -ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангилалыг сольсон тул Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно.

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан

(Дахин тайлагнасан*)

Мянган төгрөгөөр	2023	2022
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	212,117	472,368
Санхүүгийн хөрөнгө	30,078,974	23,839,304
Хорогдуулсан өртгөөр бүртгэх	27,015,498	23,839,304
Бодит үнэ цэний өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх	1,764,342	-
Бодит үнэ цэний өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх	1,299,134	-
Даатгалын гэрээний хөрөнгө	1,119,387	546,241
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	498,835	3,238,959
Авлага	43,195	23,720
Урьдчилж төлсөн төлбөр, тооцоо ба бусад хөрөнгө	257,392	189,314
Бараа материал	43,784	64,447
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	35,671
Үндсэн хөрөнгө	2,065,454	967,373
Ашиглах эрхтэй хөрөнгө	153,191	28,051
Биет бус хөрөнгө	55,782	63,751
Нийт хөрөнгө	34,528,111	29,469,199
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын гэрээний өр төлбөр	10,019,667	8,430,027
Давхар даатгалын гэрээний өр төлбөр	463,809	3,235,016
Дансны ба бусад өр төлбөр	833,795	1,191,310
Орлогын албан татварын өр төлбөр	144,337	11,733
Хойшлогдсон татварын өр төлбөр	29,475	-
Түрээсийн өр төлбөр	143,105	29,886
Нийт өр төлбөр	11,634,188	12,897,972
ЭЗДИЙН ӨМЧ		
Хувьцаат капитал	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Тусгай нөөц сан	1,388,027	1,388,027
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	1,122,806	-
Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	42,417	-
Хуримтлагдсан ашиг	15,210,673	10,053,200
Эздийн өмч	22,893,923	16,571,227
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	34,528,111	29,469,199

*Аудитлагдсан санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17 -ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангиллыг сольсон тул Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно.

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХХК
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Тусгай нөөц сан*	Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц сан	Хуримтлагд- сан ашиг	Нийт
2022 ОНЫ 1 САРЫН 1	5,000,000	130,000	1,388,027	-	-	8,044,047	14,562,074
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	3,009,153	3,009,153
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	(1,000,000)	(1,000,000)
2022 ОНЫ 12 САРЫН 31	5,000,000	130,000	1,388,027	-	-	10,053,200	16,571,227
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	42,417	1,122,806	5,157,473	6,322,696
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
2023 ОНЫ 12 САРЫН 31	5,000,000	130,000	1,388,027	42,417	1,122,806	15,210,673	22,893,923

* Тусгай нөөц санг Санхүүгийн Зохицуулах Хорооны (“СЗХ”) шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд СЗХ-той зөвшилцсөний үндсэн дээр Компанийн хувьцаа эзэмшигчид олгох боломжтой.

“ТЭНГЭР ДААТГАЛ” ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
мөнгөн гүйлгээний тайлан

(Дахин тайлагнасан*)

Мянган төгрөгөөр	2023	2022
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	5,743,143	3,324,854
<i>Татварын өмнөх ашгийг цэвэр мөнгөн гүйгээтэй тохируулах мөнгөн бус тохируулгууд:</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	107,339	104,014
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	75,535	57,020
Биет бус хөрөнгийн хорогдол	7,969	21,356
Хүүгийн орлого	(3,381,990)	(1,998,237)
Үндсэн хөрөнгийн борлуулалтаас олсон (олз) / гарз	(104,776)	(1,497)
Ханшийн бодит бус (олз) / гарз	(18,220)	90,393
Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз	10,982	893
Авлагын үнэ цэний бууралт	5,193	19,521
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	2,445,175	1,618,317
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>		
Авлагын бууралт/(өсөлт)	2,623,180	(1,575,680)
Урьдчилж төлсөн төлбөр, тооцооны өсөлт	(47,427)	(13,653)
Хойшлогдсон даатгалын орлогын шимтгэлийн өсөлт / (бууралт)	(480,870)	2,569
Давхар даатгагчид ногдох даатгалын нөөц (өсөлт)/бууралт	1,517,677	(1,521,780)
Даатгалын нөөц сангийн (өсөлт)/бууралт	71,962	139,123
Дансны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)	(2,962,527)	1,504,400
Үйл ажиллагаанаас олсон мөнгөн гүйлгээ	3,167,170	153,296
Татвар төлөлт	(387,920)	(285,213)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,779,250	(131,917)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(237,035)	(38,107)
Түрээсийн сайжруулалтын нэмэгдэлд зарцуулсан	(174,194)	-
Үндсэн хөрөнгө борлуулснаас олсон	248,215	1,649
Санхүүгийн хөрөнгө оруулалтад зарцуулсан	(6,441,913)	(665,020)
Хүлээн авсан хүүгийн орлого	3,634,784	1,919,305
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(2,970,143)	1,217,827
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Түрээсийн төлөлт	(87,578)	(56,587)
Төлсөн ногдол ашиг	-	(1,000,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(87,578)	(1,056,587)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт / (бууралт)	(278,471)	29,323
Ханшийн зөрүүний нөлөө	18,220	70,387
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	472,368	372,658
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	212,117	472,368

*Аудитлагдсан санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 17 -ийн дагуу толилуулагдсан ба зарим нэг дүнгийн ангиллыг сольсон тул Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлантай таарахгүй болно.

“CITY CENTER”, 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж
5, Ш/х-48/258
Улаанбаатар-14200

🌐 www.tengerdaatgal.mn
☎ + (976)-1800-1889
✉ insurance@tengerinsurance.mn
📱 [/tengerinsurance](https://www.facebook.com/tengerinsurance)

